



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР
ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ХАРЬЯАЛЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2022/15/35

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2022.11.29

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
УДИРТГАЛ.....	3
НЭГ. ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ИРГЭНИЙ ХЭРЭГ	4
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ОЙЛГОЛТ.....	4
ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	6
ГУРАВ. ШҮҮХИЙН ПРАКТИК	12
ДҮГНЭЛТ.....	17
ЭХ СУРВАЛЖ	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗПХ	Захиргааны процессын хууль
ИПХ	Иргэний процессын хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
ШССМХ	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

УДИРТГАЛ

Судлах зүйл

Судалгааны хүрээнд Монгол Улсын ИХШХШтХ-д тусгагдсан хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны хэргийн харьяалалд тулгамдаж буй асуудлыг авч үзнэ. Тодруулбал, хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь нэхэмжлэлээр үүсэх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагддаг шалгуур, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх зарим төрлийн хэрэг маргааныг өөр институцын харьяалалд шилжүүлэх боломжтой эсэх талаар судлах болно.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаанд онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын шүүхийн практикийг ИХШХШтХ-ийн 133, 135 дугаар зүйлүүдэд заасан маргааны төрөл тус бүрээр ангилан судлахын зэрэгцээ, харьцуулсан судалгааны хүрээнд Япон Улс болон БНХАУ-ын онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргийн харьяаллын талаар судлав.

Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ түүхчлэн судлах, харьцуулсан судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Онцгой ажиллагааны журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар ойлголт, Харьцуулсан судалгаа, Шүүхийн практик, Дүгнэлт, Эх сурвалж гэсэн хэсгээс бүрдэнэ.

НЭГ. ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ОЙЛГОЛТ

ИХШХШТХ-ийн 13 дугаар бүлэгт буюу 133-аас 155 дугаар зүйлд Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны талаар зохицуулсан.

Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргийн төрлүүд болон үндэслэлүүдийг 133 болон 135 дугаар зүйлд зохицуулсан. Үүнийг доорх хүснэгтээр харуулбал:

133.1 Шүүх дараах хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ:

- 133.1.1.эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;
- 133.1.2.хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;
- 133.1.3.сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;
- 133.1.4.хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох;
- 133.1.5.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох;
- 133.1.6.эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх;
- 133.1.7.иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох;
- 133.1.8.иргэний хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх;
- 133.1.9.нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах;
- 133.1.10.хуулийн этгээдийг дампуурсанд тооцох.

133.1.1-д тусгагдсан эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг¹ 135.1 дүгээр зүйл дараах байдлаар тодорхойлсон байна.

135.2. Эрх зүйн ач холбогдол бүхий дараах үйл явдлыг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтооно:

- 135.2.1.садан, төрлийн холбоо;
- 135.2.2.бусдын асрамжид байгаа эсэх;
- 135.2.3.төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал;
- 135.2.4.эрх олгосон ямар нэгэн баримт бичиг /иргэний үнэмлэх, гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагаас олгосон гэрчилгээнээс бусад/-т дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч нь мөн эсэх;
- 135.2.5.осол гэмтэл гарсан эсэх;
- 135.2.6.хүний ажиллаж байсан байдал;
- 135.2.7.хүүхдийн эцэг, эхийг тогтоох;
- 135.2.8.хүүхдээ тэжээн тэтгэх;
- 135.2.9.тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох;
- 135.2.10.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох;
- 135.2.11.хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах;
- 135.2.12.эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх;
- 135.2.13.нас тогтоох;
- 135.2.14.тогтоох журмыг нь хуульд заагаагүй эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл явдал.

Монгол Улсын дээд шүүхийн 2012 оны Зөвлөмжид хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааг нэхэмжлэлээр үүсгэх иргэний хэрэгтэй харьцуулан авч үзсэний үндсэн дээр,

¹ Иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд хамаарах үйл явдлыг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй (гарын авлага), 168 дахь тал.

түүний нийтлэг үндэслэл буюу онцлог шинжийн талаар **эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход нөлөөлөх үйл явдал болон эрх зүйн байдлыг тогтоодог тул энэ хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байдаггүй** хэмээх тайлбарыг хийжээ². Үүнтэй адилаар ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар ч мөн онцгой ажиллагааны журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог шинжийн талаар **эрх зүйн маргаан байдаггүй** хэмээх ерөнхий тайлбарыг хийсэн байна³.

Онцгой ажиллагаа нь тухайн хэргийг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааг хуульчлан тогтоох замаар ИХШХШТХ-ийн диспозитив зарчим, мэтгэлцэх зарчим, нээлттэй шүүх хуралдааны зарчим зэрэг нэхэмжлэлээр үүсэх маргааны ерөнхий зарчмуудаас хазайж байдаг. Энэ утгаараа, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхэд хамаарах ямар төрлийн хэргүүд байх вэ гэдэг нь иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхтэй⁴ ч холбогдох нарийн анхаарал шаардсан асуудал байдаг.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түүхэн хөгжлийн хувьд авч үзвэл, онцгой ажиллагааг онцгой ажиллагаа болгож буй эрх зүйн онол болон үндэслэл үнэхээр байдаг эсэх нь эргэлзээтэй. Тодруулбал, Ромын эрх зүйд субъектив эрх, үүрэг өөрчлөх дуусгавар болоход төр зайлшгүй оролцоод байх шаардлагагүй гэж үздэг байсан тул онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэрэг бараг байдаггүй байв⁵. Улмаар, хувь хүмүүсийн эрх үүрэг үүсэх, өөрчлөх харилцаанд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэдэг үзэл санаа бэхжихийн хэрээр онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргийн төрөл нэмэгдэж, олширсон байна⁶. Өөрөөр хэлбэл, шүүх мөн чанартаа шүүхийн чиг үүрэг бус харин захиргааны чиг үүргийг онцгой ажиллагааны хэрэгт гүйцэтгэдэг гэж хэлж болно⁷.

Ойлголтын хувьд, яг ямар төрлийн хэрэг маргааныг онцгой ажиллагаанд хамруулан авч үзэх вэ гэдэг нь мөн л асуудал дагуулдаг. Эрх зүйн маргаан бий эсэх, эсрэг тал буюу хариуцагч бий эсэх, эцсийн зорилго нь эрх зүйн үйл явдлыг тогтоох эсэх, мэтгэлцэх зарчим үйлчлэх эсэх зэрэг онцгой ажиллагааг нэхэмжлэлээр үүсгэх маргаанаас ялгах гэсэн олон төрлийн оролдлого хийгдсэн байх боловч онцгой ажиллагааг нэхэмжлэлээр үүсгэх маргаанаас ялгах гэдэг амаргүй⁸. Учир нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх маргаан гэсэн харьяалал дор хоорондоо янз бүрийн шинжээр ялгагдах төрөл бүрийн

² Монгол Улсын Дээд Шүүхийн Зөвлөмж, ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ЗАРИМ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ, 2012.12.24.

³ Монгол Улсын Дээд Шүүх, ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛБАР, 342 дах тал (Мөнхийн үсэг Нэмэлт өөрчлөлттэй 3 дахь хэвлэл 2014).

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй.” гэж хуульчилсан.

⁵ Walter Neitzel, *Non-Contentious Jurisdiction in Germany*, 21(7) Harv. L. Rev. 476, 480 (1908).

⁶ Walter Neitzel, *supra note 3*, at 480.

⁷ Walter Neitzel, *supra note 3*, at 478. Энэхүү захиргааны чиг үүргийг яагаад шүүхэд олгосон бэ гэдэг нь дараах 2 шалтгаантай. Нэгдүгээрт, **Онцгой ажиллагааны хэрэгт өөрийгөө хамгаалах чадамжгүй сул дорой этгээдүүдийн эрх ашиг хөндөгддөг** тул (хүүхэд, алга болсон этгээд, сэтгэцийн өвчтэй этгээд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч шаардлагатай этгээдүүд г.м) тэдгээр этгээдүүдийн эрх ашигийг хамгаалах чадвартай, эрх зүйн мэдлэгтэй төрийн албан хаагч тухайн этгээдүүдийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсон бөгөөд үүнд шүүгч тохирч байсан. Хоёрдугаарт, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх олон төрлийн хэрэг нь яг үнэндээ хамгийн анх нэхэмжлэлээр үүсэх маргаанаас урган гарсан бөгөөд цаг хугацааны эрхээр тухайн нэхэмжлэлээр үүсэх маргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь **автомат шинжтэй**, зүгээр хэлбэрийн төдий шаардлага болж хувирсан байдаг.

⁸ 渡部美由紀他『民事訴訟法』17頁参照（日本評論社 2016年）。

хэргүүд хуульчлагдсан байх бөгөөд тэдгээрийн нийтлэг шинж чанарыг олж тогтооно гэдэг хүндрэлтэй.

Дээрхээс авч үзвэл, **онцгой ажиллагаа гэдэг тогтсон, туйлын ойлголт биш бөгөөд үүнээс улбаатайгаар онцгой ажиллагааны харьяалал ч мөн туйлын шинж чанартай биш** юм. Хууль тогтоогч тухайн маргааны оролцогчдын эрх ашиг, эрх зүйн харилцааны тогтвортой байдал, хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх хэрэгцээ шаардлага болон нийтийн ашиг сонирхол зэргийг харгалзан үзээд аливаа маргааныг онцгой ажиллагаа болгож хувиргах, цаашлаад өөр институцийн харьяалалд шилжүүлэх бүрэн боломжтой байж болох юм.

Улмаар, манай улсын ИХШХШТХ-д тусгагдсан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргүүдийг өөр институцийн (Захиргааны хэргийн шүүх, Нотариатын байгууллага, Захиргааны байгууллага г.м) харьяалалд шилжүүлэх боломжтой эсэх талаар судалж үзэх нь зүй ёсны хэрэг ба энэ нь онцгой ажиллагааны шинэчлэл хийгдэж буй олон улс орнуудын чиг хандлагатай нийцэж байна гэж хэлж болно⁹.

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. Япон Улс

А. Ерөнхий ойлголт

Япон Улсад онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэрэг (非訟事件) болон нэхэмжлэлээр үүсэх маргаан (訴訟) хоорондын мөн чанарын ялгаа, зааг болон шүүхэд мэдүүлэх эрхийн зөрчил зэрэг нь онолын хувьд хамгийн их асуудлыг дагуулдаг. Онцгой ажиллагааны мөн чанарыг тодорхойлох, түүний хүрээ хязгаарыг тогтоох дараах хэд хэдэн тайлбаруудыг дэвшүүлсэн байдаг¹⁰.

Тус улсын Дээд шүүх (1965 он) онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх болон нэхэмжлэлээр үүсэх маргааныг хооронд нь ялгах шалгуурын тухайд *аливаа эрх, үүргийг тогтоолгох агуулгатай хэргийг нэхэмжлэлээр үүсэх маргаан гэж, харин уян хатан байдлаар (裁量的, discretion), эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх (形成的, constitutive) хэргийг онцгой ажиллагаа гэж үзэх нь зүйтэй* хэмээх тайлбарыг хийсэн байдаг (最決 (大) 昭和 40・6・30 民集 19 卷 4 号 1089 頁).

Уламжлалт тайлбарт *нэхэмжлэлээр үүсэх маргааныг шүүх урьдаас бэлтгэсэн, хийсвэр хуулийн зохицуулалтыг хэрэглэх замаар шийдвэрлэдэг бол, онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд шүүх хувь хүмүүсийн амьдралд захиргааны чиг үүргийн хувиар оролцдог* хэмээх тайлбарыг хийсэн байдаг¹¹.

Мөн, *нэхэмжлэлээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь маргааныг хүчээр, заавал дагаж мөрдөх шинжтэйгээр шийдвэрлэдэг бол, онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд хувь хүмүүс сайн дураар оролцдог* хэмээх Ромын эрх

⁹ V. V. Argounov ed., VOLUNTARY (NON-CONTENTIOUS) JURISDICTION AROUND THE WORLD 13 (Gorodets 2017).

¹⁰ 新堂幸司『新民事訴訟法』28 頁以下参照 (弘文堂 第 6 版 2019 年)。

¹¹ 兼子一『新修民事訴訟法体系』40 頁 (酒井書店 1965 年)。

зүйн түүхэн хөгжилд суурилсан тайлбар бий¹². Онцгой ажиллагааг англи хэлэнд Voluntary Jurisdiction, герман хэлэнд Freiwillige Gerichtsbarkeit¹³ гэж нэрлэдэг нь энэ тайлбартай холбоотой.

Нэхэмжлэлээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь өнгөрсөнд бий болсон маргааныг шийдвэрлэх зорилготой байдаг бол, **онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх нь ирээдүйд үүсэх маргаанаас урьдчилан сэргийлэх зорилготой** хэмээх тайлбар бий.

Харин, орчин үеийн тайлбар нэхэмжлэлээр үүсэх маргаан болон онцгой ажиллагааг онол, ойлголтын хувьд ялгахаас татгалзаж, аливаа хэрэг маргааныг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхэд хамааруулахаар болгож хуульчлах эсэх нь хууль тогтоогчийн шийдвэрлэх асуудал гэж үзэх болсон¹⁴.

Онцгой ажиллагаанд хамаарах төрөл бүрийн хэргүүд байдаг тул нийтлэг ойлголт, шинж чанарыг оновчтой тодорхойлох угаас боломжгүй тул, орчин үеийн тайлбарыг баримтлах нь зүйтэй байж болох юм.

В. Онцгой ажиллагаанд хамаарах хэргүүд

Япон Улсад онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхэд хамаарах хэргүүдийг ИПХ-д ерөнхий байдлаар бус салбар, тусгай хуулиудад зохицуулсан байдаг.

Дараах хэргүүд нь онцгой ажиллагаанд хамаарна (зөвхөн эдгээр хуулиар хязгаарлагдахгүй).

Хуулийн нэр	Зохицуулалт
Онцгой ажиллагааны журмын тухай хууль (非訟事件手続法)	<ol style="list-style-type: none"> 1. Дундын өмчлөлийг хуваасан баримт, бичгийг хадгалах этгээдийг томилох (92-р зүйл) 2. Хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх (93-р зүйл) 3. Хадгаламжийн газрыг тогтоох, хадгаламжийн зүйлийг хадгалах этгээдийг томилох (94-р зүйл) 4. Дуудлагаар худалдаалах үнийг хадгалах зөвшөөрөл (95-р зүйл) 5. Буцаан худалдан авах үнийн шинжээч томилох ((96-р зүйл) 6. Олон нийтэд шүүхийн журмаар мэдээлэх (99-р зүйл) 7. Алга болсон, гээгдүүлсэн болон хулгайд алдсан үнэт цаасыг хүчингүй болгуулах (104-р зүйл) 8. Торгууль (120-р зүйл)
Гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргааны журмын тухай хууль (家事事件手続法)	<ol style="list-style-type: none"> 1. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох 2. Алга болсон этгээдийн эд хөрөнгийг захиран, зарцуулах 3. Сураггүй алга болсон гэж зарлах 4. Гэрлэлт 5. Хүүхдийн овог өөрчлөх зөвшөөрөл авах 6. Хүүхэд үрчилж авах зөвшөөрөл авах 7. Нас барснаар гэрлэлт дуусгавар болох 8. Онцгой үрчлэлт 9. Эцэг, эх байх эрх 10. Насанд хүрээгүй этгээдийг асран хамгаалах

¹² Онцгой ажиллагааг Ромын эрх зүйд Jurisdiction voluntaria гэж нэрлэдэг байсан нь хожмоо Германы эрх зүйд Freiwillige Gerichtsbarkeit болсон.

¹³ Frei-чөлөөт, Willige-Хүсэл Зориг, Gerichtsbarkeit-Харьяалал

¹⁴ 新堂・前掲注 (8) 32 頁参照。

	<p>11. Тэжээн тэтгэх</p> <p>12. Өвлөх эд хөрөнгийг хуваах</p> <p>13. Өвийг хүлээн зөвшөөрөх, өвөөс татгалзах</p> <p>14. Эд хөрөнгийг хуваах</p> <p>15. Өвлөгч байхгүй болохыг тогтоолгох</p> <p>16. Гэрээслэл</p> <p>17. Онцгой хандив өргөх</p> <p>18. Сайн дураар харгалзан дэмжих гэрээ</p> <p>19. Гэр бүлийн бүртгэлийн тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>20. Хүйсийн чиг баримжааны онцгой ажиллагааны тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>21. Нийгмийн даатгалын тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>22. Хүүхдийн сайн сайхны байдлын тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>23. Амьдралын баталгааг хангах тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>24. Сэтгэцийн өвчин зэргийн улмаас чадамжгүй болсон этгээдийг эмчлэх тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>25. Дампуурлын тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>26. Жижиг дунд аж ахуй нэгжийн менежмент удирдлагыг залгамжлах тухай хуульд тусгагдсан хэргүүд</p> <p>27. Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалтай холбогдох хэргүүд</p> <p>28. Хөдөлмөрийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан хэргүүд</p>
<p>Компанийн тухай хуулийн онцгой ажиллагаа (会社非訟事件)</p>	<p>1. Хувьцааг худалдан авах үнийг тогтоох</p> <p>2. Алга болсон хувьцаа эзэмшигчийн хувьцааг худалдах зөвшөөрөл авах</p> <p>3. Жижиг хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурдыг зарлан хуралдуулах зөвшөөрөл авах</p> <p>4. Орон тооны бус эрх бүхий албан тушаалтан томилох</p> <p>5. ТУЗ-ын хурлын протоколтой танилцах зөвшөөрөл авах</p> <p>6. Бонд эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах</p> <p>7. Татан буулгах этгээд томилох</p> <p>8. Үүргийн гүйцэтгэлийг хангуулах</p> <p>9. Санхүүгийн баримт бичиг хадгалах этгээдийг томилох</p>

Дээрх Япон Улсын эрх зүйн зохицуулалтаас үзвэл, маш олон төрлийн хэргүүд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэг, маргаанд хамаарч байна. Эдгээрээс гэр бүлийн холбогдолтой онцгой ажиллагааны хэргүүд нь Гэр бүлийн шүүх гэсэн тусгай шүүхэд харьяалагддаг ба Япон Улсад Захиргааны хэргийн шүүх байхгүй учир бусад бүх хэргүүдийг иргэний хэргийн шүүх харьяалдаг.

2. БНХАУ

БНХАУ-ын ИПХ-ийн 15 дугаар бүлэгт онцгой ажиллагааны журмыг хуульчилсан ба дараах байдлаар зохицуулжээ.

Хуулийн нэр	Зохицуулалт
БНХАУ-ын ИПХ	<p>Нэгдүгээр хэсэг. Ерөнхий журам</p> <p>БНХАУ-ын ИПХ-ийн 177 дугаар зүйл. Ардын шүүх сонгогчийн шаардлагатай холбоотой хэрэг, сураггүй алга болсон эсхүл нас барсныг зарлах, иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай болохыг тогтоох, эзэнгүй эд хөрөнгийг тогтоох, эвлэрлийн гэрээг баталгаажуулах хэрэг, барьцааны эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаануудад энэ зохицуулалтыг хэрэглэнэ. Энэ бүлэгт зохицуулаагүй бол энэ хууль болон бусад хуулийн зохицуулалтыг хэрэглэнэ.</p>

178 дугаар зүйл. Энэ бүлэгт заасан журмаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа нь анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэх бөгөөд эцсийн шийдвэр байна. Сонгогчийн шаардлагатай холбоотой хэрэг эсхүл томоохон, төвөгтэй хэргийн хувьд шүүх бүрэлдэхүүнээр хэргийг авч хэлэлцэнэ. Бусад хэргийн хувьд нэг шүүгч дангаар шийдвэрлэнэ.

179 дүгээр зүйл. Ардын шүүх энэ бүлэгт зааснаар хэргийг хянан хэлэлцэх явцад тухайн хэрэг иргэний эрх ашигтай холбоотой маргаан илрүүлбэл онцгой ажиллагааг дуусгавар болгох захирамж гаргаж сонирхогч этгээдэд өөр нэхэмжлэл гаргах боломжтойг мэдэгдэнэ.

180 дугаар зүйл. Ардын шүүх онцгой ажиллагааны журмыг ашиглан хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол хэрэг үүсгэсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор эсхүл мэдэгдэх хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор хэргийг шийдвэрлэж дуусгана. Хэргийг сунгах шаардлагатай онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд тус шүүхийн ерөнхий шүүгчээс зөвшөөрөл авна. Энэ тохиолдолд сонгогчийн шаардлагатай холбоотой хэрэг хамаарахгүй.

Хоёрдугаар хэсэг. Сонгогчийн шаардлагатай холбоотой хэрэг

181 дүгээр зүйл. Хэрэв иргэн сонгуулийн хорооноос сонгогчийн шаардлагатай холбоотой гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл сонгуулийн өдрөөс 5 хоногийн дотор сонгууль болох газрын анхан шатны ардын шүүхэд нэхэмжлэл гаргана.

182 дугаар зүйл. Ардын шүүх сонгогчийн шаардлагатай холбоотой маргааныг хүлээн авснаас хойш сонгуулийн өдрөөс өмнө шийдвэрлэх ёстой. Хэргийг хянан хэлэлцэх явцад нэхэмжлэгч сонгуулийн хорооны төлөөлөгч болон хамааралтай иргэн заавал оролцоно.

Ардын шүүхийн шийдвэрийг сонгуулийн өдрөөс өмнө сонгуулийн хороо, нэхэмжлэгчид хүргүүлж, хамааралтай иргэнд мэдэгдэнэ.

Гуравдугаар хэсэг. Сураггүй алга болсон гэж зарлах, нас барсныг зарлах хэрэг

183 дугаар зүйл. Иргэнийг оршин суугаа газар нь тодорхойгүй 2 жил болсон бол сонирхогч этгээд сураггүй алга болсныг зарлуулах хүсэлтийг оршин суугаа газар нь тодорхойгүй байгаа хүний байнга оршин сууж байсан газрын анхан шатны шүүхэд гаргана.

Хүсэлтэд алга болсон үйл баримт, хугацаа, хүсэлтийг тодорхой бичиж цагдаагийн газрын эсхүл бусад холбогдох байгууллагын тус иргэн сураггүй алга болсон тухай бичгийн нотлох баримтыг хавсаргана.

184 дүгээр зүйл. Иргэн сураггүй алга болоод 4 жил болсон эсхүл ослын улмаас сураггүй алга болоод 2 жил болсон эсхүл ослын улмаас сураггүй алга болоод холбогдох байгууллагын тус иргэнийг амьд үлдэх боломжгүй гэж нотолсон бол сонирхогч этгээд нас барсан гэж зарлуулах хүсэлтийг оршин суугаа газар нь тодорхойгүй байгаа хүний байнга оршин сууж байсан газрын анхан шатны шүүхэд гаргана.

Хүсэлтэд сураггүй алга болсон үйл баримт, хугацаа, хүсэлтийг тодорхой бичиж цагдаагийн газрын эсхүл бусад холбогдох байгууллагын тус иргэн сураггүй алга болсонтой холбоотой бичгийн нотлох баримтыг хавсаргана.

185 дугаар зүйл. Ардын шүүх сураггүй алга болсон, нас барсныг зарлуулах хэргийг хүлээж авсны дараа сураггүй алга болсон хүнийг эрэн хайх зарлал гаргана. Сураггүй алга болсон гэж зарлахад зарлалын хугацаа 3 сар, нас барсныг зарлахад зарлалын хугацаа 1 жил байна. Ослын улмаас байгаа газар нь тодорхойгүй болсон ба цагдаагийн газраас тухайн иргэнийг амьд гарах боломжгүй гэж баталсан бол нас барсан гэж зарлах зарлалын хугацаа 3 сар байна. Зарлал гаргах хугацаа дууссан тохиолдолд Ардын шүүх сураггүй алга болсон, нас барсан үйл баримт баталгаажсан эсэхэд үндэслэн сураггүй алга болсон гэж зарлах эсхүл нас барсан гэж зарлах шийдвэр гаргах эсхүл хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргана.

186 дугаар зүйл. Сураггүй алга болсон, нас барсан гэж зарласан этгээд шинээр гарч ирсэн бол тухайн иргэн эсхүл сонирхогч этгээдийн хүсэлтээр Ардын шүүх шинэ шийдвэр гарган хуучин шийдвэрийг хүчингүй болгоно. Дөрөвдүгээр хэсэг. Иргэний иргэний эрх зүйн чадамжгүй, иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох хэрэг

187 дугаар зүйл. Иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцуулах хүсэлтийг түүний ойрын төрөл садан эсхүл сонирхогч этгээд тухайн иргэний оршин суудаг анхан шатны шүүхэд гаргана.

Хүсэлтэд тухайн иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл хязгаарлагдмал чадамжтай талаарх үйл баримт үндэслэлийг тодорхой бичнэ.

188 дугаар зүйл. Ардын шүүх хүсэлтийг хүлээн авсны дараа шаардлагатай тохиолдолд иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоолгох хүсэлт гаргасан хүнийг үнэлэн тогтоох ажиллагаа явуулна. Хүсэлт гаргасан этгээд үнэлэн тогтоосон нотлох баримт гаргасан бол шүүх үүнд шалгалт хийнэ.

189 дүгээр зүйл. Ардын шүүх иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоох хэрэгт хүсэлт гаргагчаас өөр ойрын төрөл төрөгсдийг төлөөлөгчөөр оролцуулна. Ойрын төрөл төрөгсөд төлөөлөгчөөр оролцох эсэхээ тохиролцож чадахгүй байвал Ардын шүүх төрөл төрөгсдийн дундаас нэг хүнийг төлөөлөгчөөр оролцуулахаар нэрлэн заана. Тухайн иргэн эрүүл мэндийн хувьд боломжтой байвал түүний үзэл бодлыг асууж болно.

Ардын шүүх хүсэлт үйл баримтад үндэслэсэн гэдгийг шалган тогтоовол тухайн иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэдгийг тогтоосон шийдвэр гаргана. Хэрэв үйл баримтад үндэслээгүй гэж тогтоовол татгалзсан шийдвэр гаргана.

190 дугаар зүйл. Ардын шүүх иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон иргэн эсхүл түүний асран хамгаалагчийн өргөдөлд үндэслэн тухайн иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцсон шалтгаан нэгэнт арилсан бол шинэ шийдвэр гаргаж хуучин шийдвэрийг хүчингүй болгоно. 5 дугаар хэсэг. Эд хөрөнгийг эзэнгүй гэж тогтоох хэрэг

191 дүгээр зүйл. Эд хөрөнгийг эзэнгүй гэж тогтоолгох хүсэлтийг иргэн, хуулийн этгээд эсхүл бусад байгууллага тухайн эд хөрөнгө байрлаж байгаа газрын анхан шатны шүүхэд гаргана.

Хүсэлтэд эд хөрөнгийн хэлбэр, тоо хэмжээ тухайн эд хөрөнгийг эзэнгүй гэж тогтоолгох болсон үндэслэлийг тодорхой бичнэ.

192 дугаар зүйл. Ардын шүүх хүсэлтийг хүлээн авсны дараа хянан шалгаж эд хөрөнгийг нэхэмжлэх зарлал гаргана. Зарлал гаргасны дараа 1 жил өнгөрсөн боловч эд хөрөнгийг нэхэмжлэх хүн гараагүй бол эд хөрөнгийг эзэнгүй гэж тогтоон улсын өмчид хураан авна.

193 дугаар зүйл. Эд хөрөнгийг эзэнгүй гэж тогтоосон шийдвэр гаргасны дараа эд хөрөнгийн өмчлөгч эсхүл өв залгамжлагч гарч ирэн ИХ-ийн зохицуулалтын дагуу ИХШХША-ны хугацаанд хүсэлт гаргасан бол үнэн эсэхийг шалган тогтоосны дараа шинээр шийдвэр гарган хуучин шийдвэрийг хүчингүй болгоно.

Зургаадугаар хэсэг. Эвлэрлийн хэлцлийг баталгаажуулах хэрэг

194 дүгээр зүйл. Эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулахаар хүсэлтийг талууд хамтран эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасны дагуу эвлэрүүлэн зуучлах байгууллага байрладаг анхан шатны шүүхэд эвлэрлийн хэлцэл хүчин төгөлдөр болсноос 30 хоногийн дотор гаргана.

195 дугаар зүйл. Ардын шүүх хүсэлтийг хүлээн авсны дараа хяналт шалгалт хийж хуулийн зохицуулалтад нийцсэн бол эвлэрлийн хэлцлийг хүчин

	<p>төгөлдөр гэж захирамж гаргана. Талуудын аль нэг нь хэлцлийг биелүүлэхээс татгалзсан эсхүл биелүүлээгүй бол нөгөө тал нь ардын шүүхэд хэлцлийг гүйцэтгүүлэх хүсэлт гаргаж болно. Хэлцэл хуулийн зохицуулалтад нийцээгүй бол хүсэлтийг татгалзах захирамж гаргана. Хэргийн оролцогчид эвлэрүүлэн зуучлах аргаар анхны эвлэрлийн хэлцлийг өөрчлөх эсхүл шинэ эвлэрлийн хэлцэл байгуулах эсхүл ардын шүүхэд хандах боломжтой.</p> <p>Долоодугаар хэсэг. Барьцааны эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаанууд</p> <p>196 дугаар зүйл. Барьцааны эрхийг хэрэгжүүлэх тухай хүсэлтийг барьцааны эрх эзэмшигч болон бусад барьцааны эрхийг хэрэгжүүлэх хүсэлт гаргах эрх бүхий этгээд өмчийн тухай хууль болон бусад хуульд заасны дагуу барьцааны хөрөнгө байгаа газрын эсхүл барьцаа бүртгэгдсэн газрын анхан шатны шүүхэд хандана.</p> <p>197 дугаар зүйл. Ардын шүүх хүсэлтийг хүлээн авсны дараа хянан шалгах хуульд нийцсэн гэж үзвэл дуудлага худалдаагаар худалдах, барьцаалсан хөрөнгийг худалдах тухай захирамж гаргана. Хэргийн оролцогчид уг захирамжийг үндэслэн Ардын шүүхээс шийдвэр гүйцэтгүүлэх хүсэлт гаргаж болно. Хуульд нийцээгүй гэж үзвэл хүсэлтээс татгалзах бөгөөд хэргийн оролцогчид Ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.</p>
<p>БНХАУ-ын ЗПХ</p>	<p>БНХАУ-ын ЗПХ-ийн 12 дугаар зүйлд Захиргааны хэргийн шүүхийн хүлээн авах хэргийн хүрээ хязгаарыг тогтоож өгсөн.</p> <p>ЗПХ-ийн 12 дугаар зүйлд зааснаар Ардын шүүх нь иргэн, хуулийн этгээд болон бусад байгууллагаас гаргасан дараах нэхэмжлэлийг хүлээн авна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Захиргааны журмаар баривчлах, зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг түр түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хууль бус орлогыг хураах, хууль бус эд хөрөнгийг хураах, торгох, сануулах зэрэг захиргааны шийтгэлийг эсэргүүцэх; 2. Хувийн эрх чөлөөг хязгаарлах, эд хөрөнгийг битүүмжлэх, баривчлах, битүүмжлэх зэрэг захиргааны албадлагын арга хэмжээ, захиргааны албадлагын арга хэмжээг үл зөвшөөрөх; 3. Захиргааны байгууллага нь захиргааны тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахаас татгалзсан буюу хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй, эсхүл захиргааны байгууллагаас гаргасан захиргааны тусгай зөвшөөрлийн тухай бусад шийдвэрийг эсэргүүцэх; 4. Газар, ашигт малтмалын орд, усны урсац, ой, уул, бэлчээр, эзгүй газар, түрлэг, далайн эрэг зэрэг байгалийн нөөцийг өмчлөх, ашиглах эрхийг баталгаажуулсан тухай захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй; 5. Төрийн өмчийг өмчлөх, нөхөн олговор олгох шийдвэрийг зөвшөөрөөгүй; 6. Захиргааны байгууллага хувь хүний эрх, эд хөрөнгийн эрх, хууль ёсны бусад эрх, ашиг сонирхлыг хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзсан, эсхүл хариу өгөхгүй байх; 7. Захиргааны байгууллага нь өөрийн удирдлагын бие даасан байдал буюу хөдөөгийн газрыг гэрээгээр эзэмших эрх, хөдөөгийн газрыг эзэмших эрхийг зөрчсөн гэж үзвэл; 8. Захиргааны байгууллага нь өрсөлдөөнийг үгүйсгэх, хязгаарлах зорилгоор захиргааны эрх мэдлээ урвуулан ашигласан гэж үзвэл; 9. Захиргааны байгууллага хууль бусаар хөрөнгө босгох, зардлыг хуваарилах, бусад үүргийн гүйцэтгэлийг хууль бусаар шаардсан гэж үзвэл; 10. Захиргааны байгууллага нь тэтгэвэр, амьжиргааны доод хэмжээ, нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасны дагуу олгоогүй гэж үзэж байгаа;

	<p>11. Захиргааны байгууллага хуулийн дагуу ажиллаагүй, гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй, эсхүл Засгийн газрын франчайзын гэрээ, газар, орон сууц өмчлөх нөхөн олговор олгох гэрээ болон бусад гэрээг хууль бусаар өөрчилсөн, цуцалсан гэж үзвэл;</p> <p>12. Захиргааны байгууллага нь хувийн эрх, эд хөрөнгийн эрх зэрэг хууль ёсны бусад эрх, ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл.</p> <p><i>Дээрхээс гадна Ардын шүүх нь хууль тогтоомжид заасны дагуу шүүхэд гаргаж болох бусад захиргааны хэргийг хүлээн авч болно.</i></p>
--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

БНХАУ-ын ИПХ-ийн 177 дугаар зүйлд заасны дагуу хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр зохицуулаагүй бол ИПХ болон бусад хуулийн зохицуулалтыг хэрэглэнэ. ИПХ-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу тус хуульд өөр журмаар хэлэлцэхээр зохицуулснаас бусад хэргийг Анхан шатны Ардын шүүх анхан шатны журмаар харьяалан шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, хэрэв **тухайн хэрэг ИПХ-ийн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр нэрлэн заасан хэргүүдэд хамаарахгүй, ЗПХ-ийн 12 дугаар зүйлд заасан Захиргааны хэргийн шүүхийн хүлээн авахаар заасан хэрэгт хамаарахгүй бол иргэний хэргийн анхан шатны шүүх хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр зохицуулсан** байна.

БНХАУ-ын ИПХ-д зааснаар сонгогчийн шаардлагатай холбоотой хэрэг, сураггүй алга болсон эсхүл нас барсныг зарлах, иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай болохыг тогтоох, эзэнгүй эд хөрөнгийг тогтоох, эвлэрлийн гэрээг баталгаажуулах хэрэг, барьцааны эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаануудад гэсэн нийт 6 төрлийн маргаанд онцгой ажиллагааны журмыг ашигладаг.

БНХАУ-ын ЗПХ-д зааснаар дээр дурдсан 12 төрлийн маргааныг захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэдэг ба Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан биш түүнчлэн онцгой ажиллагааны журмаар хянан хэлэлцэх маргаан биш бол БНХАУ-ын ИПХ-ийн 177 дугаар зүйлд зааснаар бол иргэний хэргийн анхан шатны шүүх хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр зохицуулсан онцлогтой байна.

ГУРАВ. ШҮҮХИЙН ПРАКТИК

Энэхүү судалгааны ажилтай холбогдуулан шүүхийн практикийг судлахдаа нээлттэй эх сурвалжид хайлт хийн буюу шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн, ШЕЗ-өөс гаргадаг тайлан, мэдээнд үндэслэлээ.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар Шүүхийн нэгдсэн тайлан хараахан гарах болоогүй байгаа тул сүүлийн 5 жилийн (бүтэн) тайлан гарсан он буюу ШЕЗ-өөс гаргасан “Шүүхийн статистик мэдээлэл”-д дурдсанаар ИХШХШТХ-аар 2017 оноос 2021 онд хянан шийдвэрлэгдсэн доорх тооны маргаан байна гэж үзжээ:

№	ИХШХШТХ-аар (онцгой ажиллагааны журмаар) хянан шийдвэрлэгдсэн маргаан	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1.	Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах /133-р зүйл/	31	26	24	30	35
2.	Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох /133-р зүйл/	33	10	41	44	40
3.	Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох /133-р зүйл/	198	185	162	159	129

4.	Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох /133-р зүйл/	8	13	7	14	22
5.	Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх /133-р зүйл/	236	218	129	160	76
6.	Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох /133-р зүйл/	41	61	21	31	9
7.	Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх /133-р зүйл/	7	3	0	4	5
8.	Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах /133-р зүйл/	2930	3677	3837	3920	4027
9.	Иргэний нас тогтоосон /135-р зүйл/	211	162	114	117	77
10.	Ажилласан жил тогтоосон /135-р зүйл/	7923	11673	7526	11641	6408
11.	Садан төрлийн холбоо тогтоосон /135-р зүйл/	35	68	157	162	43
12.	Хамтын амьдралтай байсныг тогтоосон /135-р зүйл/	493	543	486	752	785
НИЙТ		12.146	16.639	12.504	17.034	11.656

Шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн дээрх ШЕЗ-ийн тайлан мэдээнд дурдсан ИХШХШТХ-аар хянан шийдвэрлэгдсэн маргаан, тэр дундаа ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйл болон 135 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн маргааныг 2017 оноос 2022 оны 11 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд хайлт хийн дэлгэрүүлж уншиж судаллаа.

Цахим санд хайлт хийхэд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх маргаанд хамаарах доорх тооны маргаан байсан:

№	ИХШХШТХ-аар (онцгой ажиллагааны журмаар) хянан шийдвэрлэгдсэн маргаан - АНХАН ШАТНЫ ШҮҮХ	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1.	Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах	20	0	0	0	1	0
2.	Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох	9	0	0	4	0	0
3.	Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох	97	13	13	18	12	5
4.	Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох	15	22	6	10	2	2
5.	Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх	110	1	1	9	0	3
6.	Иргэний гэр бүлийн байдалд буруу бичигдсэнийг тогтоох	23	4	0	5	2	3
7.	Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх	6	0	0	0	0	0
8.	Хариуцагчийг нэхэмжлэгчийн хүсэлтээр эрэн сурвалжлах	1297	70	66	53	33	15
9.	Нас тогтоолгох	106	2	1	4	2	0
10.	Ажилласан жил тогтоолгох	4211	939	612	799	182	75
11.	Садан төрлийн холбоо тогтоолгох	24	3	9	15	2	0
12.	Хамтын амьдралтай байсныг тогтоолгох	266	47	29	34	12	10
НИЙТ		6184	1101	737	951	248	113

Дээрх тоон мэдээллээс харвал, тухайн хэргийн нууцлал зэрэг шалтгааны улмаас хянан шийдвэрлэгддэг нийт маргааны тун хангалтгүй хувь нь шүүхийн шийдвэрийн цахим санд орж буюу нээлттэй цахим эх сурвалжид нийтлэгддэг сул тал байж болохуйц байна.

Судалгааны ажлын хүрээнд Иргэний хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд дээрх 12 ангиллын онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдсэн маргаан, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн маргааныг хамруулан “иргэний болон захиргааны хэргийн хянан шийдвэрлэх маргаанд хэргийн харьяалал давхардсан эсэх” талаар дүгнэлт өгөхийг зорин судалсан.

Ийнхүү судалгааны үндсэнд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх 12 төрлийн маргааны талаар дараах дүгнэлтийг хийж болохоор байна:

- 1) Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах хүсэлтийг шүүхэд бусад онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх маргаанаас харьцангуй бага гаргадаг ба энэ талаар иргэний болон захиргааны хэргийн шүүхийн хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 2) Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай гэж тооцуулах хүсэлтийг мөн шүүхэд харьцангуй цөөн гаргадаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 3) Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох хүсэлтийн хувьд иргэний хэргийн шүүхэд хүсэлт гаргахдаа “Нэхэмжлэгч шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа ... Эхнэр өвчний улмаас нас барсан, миний бие өвчний улмаас цаашид асах боломжгүй болсон тул охиноо төрсөн эцэг, эхэд нь буцааж өгөхөөр үрчлэлтийг хүчингүй болгуулах хүсэлтэй байна. “Захиргааны байгууллагаар явсан боловч хүлээж авахгүй байна” гэсэн маргаан байсан. Гэсэн хэдий ч энэ асуудлыг шүүхээс шийдвэрлэхдээ захиргааны байгууллагад хандсантай холбоотой ямар нэг дүгнэлт хийгээгүй ба энэ нь хүүхэд үрчлэлттэй холбоотой харилцаанаас үүдэх маргааныг иргэний хэргийн шүүх эсхүл захиргааны хэргийн шүүхийн хэргийн харьяалалд нөлөөлөхүйц дүгнэлт хийх боломжит шийдвэр биш болно;
- 4) Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох хүсэлтийг мөн цөөн тохиолдолд гаргадаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 5) Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх хүсэлт шүүхийн практикт мөн бусад төрлийн хүсэлттэй харьцуулахад цөөн гардаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 6) Иргэний гэр бүлийн байдалд буруу бичигдсэнийг тогтоох хүсэлт шүүхийн практикт цөөн гардаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 7) Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх хүсэлт гаргасан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр 2017-2022 оны хугацаанд бараг байгаагүй гэж хэлж болохоор ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 8) Хариуцагчийг нэхэмжлэгчийн хүсэлтээр эрэн сурвалжлах хүсэлт шүүхийн практикт нэлээдгүй гардаг ба энэ талаар дүгнэлт хийсэн¹⁵;

¹⁵ Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж, “Онцгой ажиллагааны журмаар зарим хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал”-д дурдсанаар “Шүүх онцгой ажиллагааны журмаар эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоодог ч нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах ажиллагаа нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалд хамаардаггүй” байна. Хайлт хийн судалсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл “гэрээний үүргээ биелүүлээгүй” үндэслэлээр тухайлбал Зээлийн гэрээ, Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ, Худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой үүргийн гүйцэтгэл хангуулахын тулд хариуцагчийг эрэн сурвалжлуулах, мөн гэрлэлт цуцлуулах болон хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэл шүүхэд гаргахын тулд хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлтийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр дийлэнх хувийг эзэлж байна. Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд мөн эсэхийг гагцхүү шүүгч хянан шалгасны үр дүнд эрэн сурвалжлуулах захирамжийг

- 9) Нас тогтоолгох хүсэлт харьцангуй цөөн гардаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 10) Ажилласан жил тогтоолгох хүсэлт онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамгийн ихээр гаргадаг хүсэлт боловч нээлтэй санд буюу шүүхийн шийдвэрийн цахим санд түүний их бага хувь нь байршдаг байна. Тэдгээрийг уншиж судлан дүгнэхэд, энэ төрлийн хүсэлтийн хувьд ихэнх тохиолдолд хангаж шийдвэрлэсэн байх ба хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй болно;
- 11) Садан төрлийн холбоо тогтоолгох хүсэлт харьцангуй цөөн гардаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй;
- 12) Хамтын амьдралтай байсныг тогтоолгох хүсэлт харьцангуй цөөн гардаг ба энэ талаар хэргийн харьяалал давхацсан зүйл байгаагүй болно.

Монгол Улсын Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэж буй иргэний хэргийн шүүхийн практикийг дүгнэн үзвэл, хүсэлтээр үүссэн тухайн маргааныг “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан мөн” гэж дүгнэсэн, шийдвэрлэхгүйгээр орхисон, хүсэлтийг дурдсан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон маргаан байгаагүй болно.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017-2022 оны шийдвэрлэсэн улсын бүртгэлтэй холбоотой ангиллын маргаанд дүгнэлт хийн судлахад, иргэний хэргийн шүүхэд улсын бүртгэлтэй холбоотойгоор хөдөлмөрийн дэвтрийн жинхэнэ эзэмшигчээр тогтоолгох нэхэмжлэл (хүсэлт) гаргасны дараагаар захиргааны хэргийн шүүхэд хандан “иргэний бүртгэлийн бичиг баримтыг ...-р бүртгэхийг Улсын бүртгэлийн хэлтэст даалгахыг хүссэн” шаардлага гаргах тохиолдол байдаг¹⁶, ИХШХШТХ-ийн 135.2.14-т зааснаар эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл явдал буюу орон сууцанд амьдарч байсныг тогтоон шийдвэрлэсний дараагаар Захиргааны хэргийн шүүхэд хандан “Дархан-Уул аймгийн Орон сууц хувьчлалын товчооны 2004 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 32 дугаар тогтоолын М.Болормаад холбогдох хэсэг, улсын бүртгэлийн 2003017236 дугаар бүртгэл, орон сууц өмчлөх гэрчилгээг тус тус хүчингүй болгуулах тухай” шаардлага гаргасан¹⁷, “Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын улсын байцаагчийн 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох тухай” 02/12-02-02/12-02-03 дугаар албан шаардлагын нэхэмжлэгч нарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” шаардлагатай

гаргана хэмээн “Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэлт ба шүүгчийн ачаалал бодлогын судалгааны тайлан”-д дурджээ. Дээрх шүүхийн шийдвэрүүдэд “Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд” гэдэгт гэрээний оролцогч тал оршин суугаа хаягтаа байхгүй нь нотлогдсон эсвэл гэрлэлт цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах зэрэг хэрэгт хариуцагч оршин суугаа газартаа байхгүй нь нотлогдсон бол шүүх хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн байна. Гэхдээ зарим хэрэгт иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцвол зохих этгээд гэдэгт хамаарахгүй, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн хүнийг эрэн сурвалжлуулах хүсэлт гаргасан, үүнийг нь шүүх хангаж шийдвэрлэсэн тохиолдлууд байна. Тухайлбал: Дорноговь аймгийн Замын-үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 17-ний өдөр шийдвэрлэсэн 256 дугаартай шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Х.Г нь 2017 оны 06 сарын 09-ний өдөр 2.500.000 төгрөгийг Солонгос улсад ажлын гэрээгээр явах зорилгоор өгсөн боловч яваагүй, эргүүлэн мөнгөө олж авч чадаагүй, Х.Г нь оршин сууж байсан хаягтаа байхгүй алга болсон байх тул түүнийг эрэн сурвалжлах үндэслэлтэй гэж шүүх үзлээ” гэжээ. Манай улсын хувьд онцгой ажиллагааны журмаар хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлтийг хангахдаа иргэний хэрэгт хариуцагчаар оролцох этгээд мөн эсэхэд дүгнэлт өгөөгүй, иргэний хэрэгт хариуцагчаар оролцох этгээд биш байхад хүсэлтийг ханган шийдвэрлэж байгаа нь шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх, шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх зарчим зөрчигдөх сөрөг үр дагавартай байна.

¹⁶ Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.05.29-ний өдрийн 13 дугаар шийдвэр. https://shuukh.mn/single_case/6685?daterange=2020-01-01%20-%202020-12-31&id=1&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2022.11.28).

¹⁷ Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.05.19-ний өдрийн 16 дугаар шийдвэр. [HTTPS://SHUUKH.MN/SINGLE_CASE/4533?DATERANGE=2018-01-01%20-%202018-12-31&ID=1&COURT_CAT=3&BB=1](https://shuukh.mn/single_case/4533?daterange=2018-01-01%20-%202018-12-31&id=1&court_cat=3&bb=1) (Сүүлд үзсэн: 2022.11.28).

маргаанд “нэхэмжлэгч нар Хан-Уул дүүргийн иргэний хэргийн шүүхэд нас барагчтай хамтын амьдралтай байсныг тогтоолгох шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргасан, шүүх ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2.14 дэх хэсэгт зааснаар хамтын амьдралтай байсан болохыг тогтоосон, дээрх нэхэмжлэгч нар эцэг тогтоолгох болон төрүүлсэн хүүхдээ бусдын асаргаанд байсныг тогтоолгох нэхэмжлэлийг мөн тус шүүхэд гаргасан боловч ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.6-д зааснаар тодруулбал “нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан үйл баримт тогтоогдож байна” гэсэн боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч нь нэхэмжлэлээсээ татгалзсан тул Захиргааны хэргийн шүүхээс татгалзлыг баталж шийдвэрлэсэн байна¹⁸, хамтын амьдралтай байсныг тогтоолгох хүсэлтийг иргэний хэргийн шүүхээс хангаж шийдвэрлэсний дараа “А аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгохгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, Б.А-д тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгохыг А аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт даалгах тухай” нэхэмжлэл захиргааны хэргийн шүүхэд гаргаж хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч эвлэрч¹⁹ дуусгавар болжээ.

Дээрхээс дүгнэн үзвэл, Захиргааны хэргийн шүүхийн практикт (нэн ялангуяа, улсын бүртгэлтэй холбоотой маргааны хувьд) иргэний хэргийн шүүхэд хандсаны дараагаар “улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг даалгах” гэх мэт шаардлага буюу нэхэмжлэл гарган Захиргааны хэргийн шүүхэд хандах тохиолдолд ховор байх хэдий ч, огт байдаггүй биш байна. Харин Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн маргааны хувьд Захиргааны хэргийн шүүхийн харьяалал тул хэргийг хэрэгсэхгүй болгосон эсхүл шийдвэрлэхээс татгалзсан тохиолдол байхгүй байна.

Иймд иргэдийн шүүхэд хандах эрхийг цаг алдалгүй, баталгаатай хэрэгжүүлэх, “нэг маргааныг нэг удаа шийдвэрлэх” буюу иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсны дараагаар улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг даалгах тухай захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх замаар цаг хугацааны хувьд алдагдалтай, шүүхийн үйл ажиллагаанд ч хийсвэр ачаалал нэмэхгүйгээр судалгааны эхний хэсэгт дурдсанчлан бусад гадаад улсын сайн туршлага (best practice)-д үндэслэн ИХШХШТХ-ийн 133 болон 135 дугаар зүйлд тусгагдсан маргааныг аль тохиромжтой хэсгийг Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэдэг байх (жишээ нь: улсын бүртгэлтэй холбоотой хэсгийг Захиргааны хэргийн шүүх шийдэх), эсхүл Захиргааны байгууллага шийдвэрлэх (жишээ нь: улсын бүртгэлтэй холбоотой хэсгийг захиргааны байгууллага буюу Улсын бүртгэлийн ерөнхий газар шийдвэрлэх, түүнийг нь үл зөвшөөрвөл Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байх) зэргээр зохицуулах нь оновчтой алхам, гарц байж болох юм гэж үзлээ.

¹⁸ Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхийн 2019.10.07-ны өдрийн 653 дугаар шийдвэр. https://shuukh.mn/single_case/6192?daterange=2019-01-01%20-%202019-12-31&id=1&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2022.11.28).

¹⁹ Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020.01.29-ний өдрийн 05 дугаар захирамж. https://shuukh.mn/single_case/6046?daterange=2020-01-01%20-%202020-12-31&id=1&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2022.11.28).

ДҮГНЭЛТ

ИХШХШтХ-ийн 133 болон 135 дугаар зүйлүүдэд “онцгой ажиллагааны журмаар” хянан шийдвэрлэх иргэний хэргүүдийг хуульчилж өгсөн ба энэ төрлийн хэргүүд нь тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т зааснаас хүсэлтээр үүсэх, 82 дугаар зүйлийн 82.1.6-д зааснаар шүүгч дангаар хянан шийдвэрлэх онцлогтой билээ.

Хүсэлтээр үүсгэх маргаан нь нэхэмжлэлээр үүсгэх маргаанаас ялгагдах гол шинж нь “эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход нөлөөлөх үйл явдал болон эрх зүйн байдлыг тогтоодог тул энэ хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байдаггүй” гэж тодорхойлсон байдаг.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түүхэн хөгжлийн хувьд авч үзвэл Ромын эрх зүйгээс эхлэлтэй. Тодруулбал, Ромын эрх зүйд субъектив эрх, үүрэг өөрчлөх дуусгавар болоход төр зайлшгүй оролцоод байх шаардлагагүй гэж үздэг байсан тул онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэрэг бараг байдаггүй байсан байна. Улмаар, хувь хүмүүсийн эрх үүрэг үүсэх, өөрчлөх харилцаанд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэдэг үзэл санаа бэхжихийн хэрээр онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргийн төрөл нэмэгдэж, олширсон төдийгүй энэ төрлийн маргааны хувьд шүүх мөн чанартаа шүүхийн чиг үүрэг бус харин захиргааны чиг үүргийг онцгой ажиллагааны хэрэгт гүйцэтгэдэг.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд ямар төрлийн маргааныг хамааруулан хуульчлах нь бусад улсад ч мөн маргаан дагуулдаг сэдвийн нэг мөн. Учир нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх маргаан гэсэн харьяалал дор хоорондоо янз бүрийн шинжээр ялгагдах төрөл бүрийн хэргүүд хуульчлагдсан байх бөгөөд тэдгээрийн нийтлэг шинж чанарыг олж тогтооно гэдэг хүндрэлтэй. Иймд онцгой ажиллагаа гэдэг тогтсон, туйлын ойлголт биш бөгөөд үүнээс улбаатайгаар онцгой ажиллагааны харьяалал ч мөн туйлын шинж чанартай биш гэж дүгнэх боломжтой байхыг үгүйсгэх аргагүй юм.

Үүнээс гадна, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааныг нэхэмжлэлээр үүсэх иргэний маргаанаас хэрхэн яаж ялгах нь хүндрэлтэй асуудал үүсгэдэг ба ерөнхийд нь авч үзвэл, иргэний хэрэг үүсгэх дээрх хоёр төрлийн үндэслэлийг “эрх зүйн маргаан байгаа эсэх, мэтгэлцэх зарчим үйлчлэх эсэх, хэргийн оролцогчийн эрх ашгийг хангаж хамгаалахын тулд түргэн шуурхай шийдвэрлэх шаардлагатай” гэсэн шалгуурыг түлхүү баримтлан ялгах хандлагатай байна гэж үзлээ.

Бусад гадаад улсын эх сурвалжид дурдсан сонирхолтой бөгөөд дэвшилттэй байж болохуйц санаа нь энэ төрлийн маргааны харьяаллыг заавал иргэний хэргийн шүүхэд эсхүл бүр шүүхийн байгууллагад харьяалуулахаас өөр замаар зохицуулалт хийх боломж нь тухайн маргааныг хянан шийдвэрлэх боломжийг нотариатын байгууллага, захиргааны байгууллагад шилжүүлэх явдал байж болох юм гэж үзсэн болно. Түүнчлэн, өөр нэг сонголт бүхий хувилбар байж болох нь ИХШХШтХ-ийн 133, 135 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааны (зарим төрлийн маргаан, жишээлбэл: улсын бүртгэлтэй холбогдох хэсэг) зарим хэсгийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй байхаар тусгах нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсэн эрхийг боломжит богино хугацаанд сэргээх боломж бүрдүүлэх, шүүхийн зардал, цаг хугацааг хэмнэх давуу талтай байж болохуйц байж болох юм.

Харьцуулсан судалгааны хүрээнд сонгон судалсан Япон Улс нь нэхэмжлэлээр үүсгэх маргаан болон онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааны хоорондын мөн

чанарын ялгаа, зааг болон шүүхэд мэдүүлэх эрхийн зөрчил зэрэг нь онолын хувьд хамгийн их асуудлыг дагуулдаг. Тус улсын Дээд шүүхээс “аливаа эрх, үүргийг тогтоолгох агуулгатай хэргийг нэхэмжлэлээр үүсэх маргаан гэж, харин уян хатан байдлаар, эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх хэргийг онцгой ажиллагаа гэж үзэх нь зүйтэй” гэж тайлбарласан байдаг байна. Япон Улсын ИПХ-д бус салбарын бусад хуулиар онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааныг зохицуулсан байдаг. Жишээлбэл: Онцгой ажиллагааны журмын тухай хуульд тусгагдсан алга болсон, гээгдүүлсэн болон хулгайд алдсан үнэт цаасыг хүчингүй болгуулах хэрэг, Гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргааны журмын тухай хуульд заасан сураггүй алга болсон гэж зарлах, эцэг эх байх эрхтэй холбоотой маргаан г.м

Тус улсын онцлог нь салбар хуульд тусгагдсан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргаан ихтэй ба Захиргаан хэргийн шүүх байдаггүй тул Гэр бүлийн шүүхэд харьяалагдахаас бусад төрлийн маргааныг Иргэний хэргийн шүүх өөрийн харьяаллын маргаан гэж үзэж шийдвэрлэдэг байна.

БНХАУ-ын хувьд онцлог зохицуулалт нь аливаа маргаан нь ИПХ-ийн 177 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй, түүнчлэн ЗПХ-ийн 12 дугаар зүйлд заасан захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарахгүй маргааныг иргэний хэргийн шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэхээр хуульчилсан явдал юм. БНХАУ-ын хувьд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааныг 6 үндсэн төрөлд хувааж болох ба тэдгээр нь сонгогчийн шаардлагатай холбоотой хэрэг, сураггүй алга болсон эсхүл нас барсныг зарлах, иргэнийг иргэний эрх зүйн чадамжгүй болон хязгаарлагдмал чадамжтай болохыг тогтоох, эзэнгүй эд хөрөнгийг тогтоох, эвлэрлийн гэрээг баталгаажуулах хэрэг, барьцааны эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаан болно. БНХАУ-ын ИПХ болон ЗПХ-д улсын бүртгэлтэй холбоотой маргааны хэргийн харьяаллын талаар нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын шүүхийн практикийн хувьд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсны дараагаар захиргааны хэргийн шүүхэд хандан нэхэмжлэл гаргаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тохиолдол огт байхгүй биш боловч маш ховор байна (иргэний хэргийн шүүхэд хандсаны дараагаар “улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг даалгах” гэх мэт шаардлага буюу нэхэмжлэл гарган Захиргааны хэргийн шүүхэд хандах тохиолдол) гэж үзсэн. Учир нь 2017-2022 оныг хүртэлх шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн судлахад иргэний хэргийн шүүхэд хүсэлт гарган хянан шийдвэрлүүлсэн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргаанд захиргааны хэргийн шүүхийн харьяалалтай давхацсан зүйл байгаагүйгээс гадна хэргийн харьяалал зөрчсөн эсхүл иргэний хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан биш гэсэн үндэслэлээр шийдвэрлэхээс татгалзсан шийдвэр байгаагүй болно. Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хамгийн түгээмэл, олон тоогоор гардаг маргаан нь ажилласан жил тогтоолгохтой холбоотой хэрэг маргаан байлаа.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн 2017-2022 оны маргааныг судлан дүгнэвэл, иргэдийн шүүхэд хандах эрхийг цаг алдалгүй, баталгаатай хэрэгжүүлэх, “нэг маргааныг нэг удаа шийдвэрлэх” буюу иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсны дараагаар улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг даалгах тухай захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх замаар цаг хугацааны хувьд алдагдалтай, шүүхийн үйл ажиллагаанд ч хийсвэр ачаалал нэмэхгүйгээр судалгааны эхний хэсэгт дурдсанчлан бусад гадаад улсын сайн туршлага (best practice)-д үндэслэн ИХШХШТХ-ийн 133 болон 135 дугаар зүйлд тусгагдсан маргааныг аль тохиромжтой хэсгийг Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэдэг байх (жишээ нь: улсын бүртгэлтэй холбоотой хэсгийг Захиргааны хэргийн шүүх шийдэх), эсхүл Захиргааны байгууллага шийдвэрлэх (жишээ нь:

улсын бүртгэлтэй холбоотой хэсгийг захиргааны байгууллага буюу Улсын бүртгэлийн ерөнхий газар шийдвэрлэх, түүнийг нь үл зөвшөөрвөл Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байх) зэргээр зохицуулах нь оновчтой алхам, гарц байж болох юм гэж үзлээ.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, зөвлөмж:

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
3. “Онцгой Ажиллагааны Журмаар Зарим Хэргийг Хянан Шийдвэрлэхэд Анхаарах Асуудал”, Монгол Улсын Дээд Шүүхийн Зөвлөмж, 2012 он.

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй (гарын авлага).
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар.
3. Walter Neitzel, Non-Contentious Jurisdiction in Germany.
4. V. V. Argounov ed., VOLUNTARY (NON-CONTENTIOUS) JURISDICTION AROUND THE WORLD.
5. 新堂幸司『新民事訴訟法』28頁以下参照（弘文堂 第6版 2019年）。
6. 兼子一『新修民事訴訟法体系』40頁（酒井書店 1965年）。

Шүүхийн шийдвэр:

1. Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.05.29-ний өдрийн 13 дугаар шийдвэр.
2. Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018.05.19-ний өдрийн 16 дугаар шийдвэр.
3. Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхийн 2019.10.07-ны өдрийн 653 дугаар шийдвэр.
4. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 08 сарын 10 өдрийн 02210 дугаартай шийдвэр.
5. Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020.01.29-ний өдрийн 05 дугаар захирамж.

Цахим эх сурвалж:

1. <https://shuukh.mn/>